



**ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН  
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН  
ТУШААЛ**

2020 оны 01 сарын 03 өдөр

Дугаар 103

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалт, 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэг, 47 дугаар зүйлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хоол хүнс худалдан авах ажиллагааг хэрэгжүүлэх Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Үнэлгээний хорооны дарга: Ч.Батболд, Стратеги төлөвлөлт, санхүү бүртгэлийн албаны дарга  
Нарийн бичгийн дарга: Б.Өнөрцэцэг, Сувилахуйн албаны дарга  
Гишүүд: Э.Тунгалагтуяа, Чанарын менежер  
Г.Мөнхзаяа, Хөндлөнгийн гишүүн  
Х.Цогтбаяр, Хөндлөнгийн гишүүн

2. Худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журамд нийцүүлэн зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Үнэлгээний хорооны дарга /Ч.Батболд/-д, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Авилгын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг чанд мөрдөн авлига, ашиг сонирхолын зөрчлөөс ангид ажиллахыг Үнэлгээний хорооны гишүүдэд тус тус үүрэг болгосугай.

3. Үнэлгээний хорооны гишүүдээс холбогдох мэдэгдэл, тайлбар гаргуулан авч, авилга, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллахыг Үнэлгээний хорооны дарга /Н.Халиун/, Эрх бүхий албан тушаалтан /Я.Тогтохням/-д тус тус даалгасугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Н.ЭРДЭНЭБАЯР